

**ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2012 оны 07 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 162

Улаанбаатар хот

Журам, маягтын загвар батлах тухай

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1.6, 13.2 дугаар зүйл, Монгол улсын Засгийн газрын 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам"-ын 2.12 дугаар заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Гэрийн халамж, асрамжийн үйлчилгээний журмыг 1 дүгээр хавсралтаар, Гурав ба түүнээс дээш ихэр, хүүхдийг төрийн зардлаар өсгөж, хүмүүжүүлэх журмыг 2 дугаар хавсралтаар, "Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг асрах гэрээ"-ний загварыг 3 дугаар хавсралтаар, "Хүүхэд асран тэтгэх гэрээ"-ний загварыг 4 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалт гарсан холбогдуулан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 129, 69 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Батлагдсан журам, аргачлалыг орон нутагт хэрэгжүүлэх, маягтыг олшруулан үйл ажиллагаандаа хэрэглэх ажлыг зохион байгуулахыг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга нарт зөвшөөрсүгэй.

4. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг газрын Дэд дарга /Ж.Эрдэнбаатар/ Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга /М.Ариунжаргал/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ГЭРИЙН АСРАМЖ, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

1. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаагүй, бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ асаргаа шаардагдах ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний гэрийн халамж, асрамжийн үйлчилгээ авах тухай хүсэлтээ гаргавал аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагаас зохих төлбөртэй болон төлбөргүй үйлчилгээ үзүүлэхэд энэхүү журмыг баримтална.

2. Гэрийн халамж, асрамжийн үйлчилгээ дор дурдсан төрөлтэй байж болно.

- Гэр барих, цонх хаалга угаах, дулаалах
- Хүнсний зүйл цуглуулах, хоол хийх, хооллох
- Цагаан хэрэглэл, хувцасыг угаалга цэвэрлэгээнд хүргэж өгөх, авч ирэх
- Агаар, нар салхинд гаргах, усанд оруулах, үс засуулах
- Эмнэлэгт үзүүлэх, эм тариаг эмийн сангаас авч өгөх, эмийн бус эмчилгээ үйлчилгээ үзүүлэх
- Сонин хэвлэл захиалах, шуудан, номын сангийн үйлчилгээ авахад нь туслах, үзвэр үзүүлэх, тоглоом тоглуулах
- Түлээ, нүүрс худалдан авах, мод хөрөөдөж хагалах
- Тохирсон хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх
- Эрүүл мэнд, амьдрах ухааны зэрэг сургалт үйлчилгээнд хамруулах

3. Сум, хорооны нийгмийн ажилтан нь гэрийн халамж, асрамжийн төлбөртэй болон төлбөргүй үйлчилгээнд хамрагдах ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг гаргаж аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.

4. Гэрийн халамж, асрамжийн үйлчилгээг үзүүлэхдээ төрийн бус байгууллага, сайн дурын идэвхтний өөрсдийнх нь хүсэлтээр гүйцэтгүүлж болно.

5. Төрийн бус байгууллага, сайн дурын идэвхтнээр гэрээгээр гүйцэтгүүлэх гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг сум, хорооны нийгмийн ажилтан,

үйлчлүүлэгч, үйлчлэгч гэсэн гурвалсан гэрээ байгуулах ба үйлчилгээ үзүүлэх хугацаа, үйлчилгээний төрлийг тогтоож, Засаг даргаар батлуулан ажиллана. Төрийн бус байгууллага, сайн дурын идэвхтэн байхгүй тохиолдолд ажил идэвхтэй эрж байгаа бүртгэлтэй иргэдээс байнгын үйлчлэгч томилон ажиллуулж болно. Үйлчлэгчийн ажлын ачааллыг орон нутгийн онцлогоос шалтгаалан тогтоох бөгөөд сарын цалин, хөлс нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна.

6. Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээний чанарт сум, хорооны нийгмийн ажилтан, үйлчлүүлэгч нар хамтран хяналт тавина.

7. Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг чанаргүй гүйцэтгэсэн, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хохироосон тохиолдолд сум, хорооны нийгмийн ажилтан гэрээг зогсоох тухай эрх бүхий байгууллагад асуудлыг тавьж, холбогдох хууль тогтоомжуудын дагуу шийдвэрлүүлнэ.

Гэрийн асрамж, халамжийн төлбөргүй үйлчилгээ

8. Өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй, ядуу, нэн ядуу амьдралтай, ганц бие, гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн хүсэлтээ гаргавал тэдэнд төлбөргүй үйлчилгээг үзүүлнэ.

9. Гэрийн асрамж, халамжийн төлбөргүй үйлчилгээнд хамруулахдаа тухайн иргэний оршин суугаа баг, хорооны Засаг даргын тодорхойлолтыг үндэслэнэ.

10. Нэн ядуу амьдралтай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд төлбөргүй хамруулсан тохиолдолд үйлчлэгчийн сарын цалин, бусад холбогдох зардлыг Нийгмийн үйлчилгээний сангаас олгоно.

Гэрийн халамж, асрамжийн төлбөртэй үйлчилгээ

11. Орон байртай, ядуу бус боловч өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй ганц бие ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэрийн үйлчлэгч шаардлагатай тухай хүсэлтээ албан ёсоор тавьсан тохиолдолд тэдэнд төлбөртэй үйлчилгээг үзүүлж болно.

12. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн төрөлжсөн асрамжийн газар болон бусад халамж, асрамжийн төвд тодорхой хугацаанд байрлан асруулахаар бол ор хоногийн хөлсөнд хоолны үнэ болон бусад бүх төрлийн үйлчилгээний хөлс багтсан байна.

13. Асрамжийн газар болон бусад халамж, асрамжийн төв нь өөрсдийн үзүүлэх төлбөртэй үйлчилгээний төрөл тус бүрт тохирсон үнэ тарифыг тогтоон харъяалагдах аймаг, дүүрэг, сум, хорооны Засаг даргын тамгын газартай зөвшилцөн баталж мөрдөнө.

14. Төлбөртэй үйлчилгээнд хамрагдах тухай хүсэлт гаргасан иргэнтэй сум, хорооны нийгмийн ажилтан, үйлчлэгч гурвалсан гэрээ байгуулан ажиллана. Гэрээнд үйлчилгээ үзүүлэх хугацаа, үйлчилгээний төрөл, төлбөрийн талаар тодорхой тусгасан байна.

15. Гэрийн үйлчилгээ үзүүлэх гэрээг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга, гүйцэтгэгч байгууллагатай хийж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга батална.

ГУРАВ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ИХЭР ХҮҮХДИЙГ ТӨРИЙН ЗАРДЛААР ӨСГӨЖ, ХҮМҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

1. Энэхүү журмаар гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийг /цаашид ихэр хүүхэд гэнэ/ 4 нас хүртэл нь төрийн зардлаар асрамжлан өсгөж, хүмүүжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

2. Ихэр хүүхдийг асрамжлан өсгөж, хүмүүжүүлэх үйлчилгээг хүүхэд асрах байнгын болон өдрийн үйлчилгээтэй /төрийн болон хувийн хүүхдийн асрамжийн газар, ясли, цэцэрлэг/ байгууллагууд эрхлэн гүйцэтгэнэ.

3. Аймаг, хот, сумын эмнэлэг, төрөх газар ихэр хүүхдийг төрсөн өдрөөс эхлэн нэг сартай болох хүртэл хугацаанд эмнэлгийн хяналтанд эхтэй нь хамт асрамжлана. Энэ хугацааны эхийн хоолны зардлыг эмнэлэг, төрөх газар хариуцна.

4. Эцэг, эх нь хүсэлт гаргавал ихэр хүүхдийг 4 настай болтол нь аймаг, хотын хүүхэд асрах газарт төрийн зардлаар асрамжлан өсгөж хүмүүжүүлнэ. Тухайн орон нутагт нь зохих түвшинд асрамжлан өсгөж хүмүүжүүлэх бололцоогүй бол нийслэлийн хүүхэд асрах газарт эхтэй нь хамт шилжүүлэн асарч болно.

5. Эцэг, эх нь ихэр хүүхдээ гэртээ эсэн мэнд асрамжлан өсгөж байгаа бол жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг хүүхэд тус бүрт олгоно.

6. Ихэр хүүхдийг 4 нас хүртэл нь эмнэлгийн байгууллагын хяналтанд байлгах ба үүнтэй холбогдон гарах зардлыг эмчилгээ, үйлчилгээ үзүүлсэн тухайн эмнэлгийн байгууллага хариуцна.

7. Төрийн зардлаар асрамжлан өсгөж хүмүүжүүлж байгаа ихэр хүүхдийн хоол тэжээл, хувцасны зардлыг зохих нормативийн дагуу болон хүүхдээ харж байгаа эхийн хоолны зардлыг асрамжийн газрын нэг асруулагчийн /байнгын/ нормативийн дагуу санхүүжүүлнэ.

8. Энэ журмын 5, 7-д заасан зардлыг орон нутгаас нийслэлд хотод ирэх, буцах унааны зардлыг тухайн аймаг, дүүргийн Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нийгмийн үйлчилгээний сангаас санхүүжүүлэх бөгөөд жил бүрийн төсөвт тусган батлуулна.

БАТЛАВ. АЙМАГ, ДҮҮРГИЙН ХХҮХ-ИЙН ДАРГА / /

**АХМАД НАСТАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭН,
ХҮҮХЭД АСРАХ ТУХАЙ ГЭРЭЭ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Гэрээний зорилго нь: Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.2.1, 13.2.3, 13.2.4 дүгээр зүйлд заасан, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа болон хөдөлмөрийн насны иргэнээс гадна ахмад настан болон 16-гаас дээш насны хүүхдэд асаргааны тэтгэмж олгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. аймаг, дүүргийн сум, хорооны нийгмийн ажилтан овогтой /цаашид нийгмийн ажилтан энэ/, сум, хорооны ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд хаягт оршин суудаг /иргэний үнэмлэх № регистрийн №/ овогтой /цаашид асруулагч гэнэ/, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг асарч буй иргэн аймаг, дүүргийн сум, хорооны иргэн /иргэний үнэмлэх № регистрийн №/ овогтой /цаашид асрагч гэнэ/ бид харилцан тохиролцож, асаргааны тэтгэмж олгох тухай сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөл, Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор энэхүү гурвалсан гэрээг байгуулав.

Хоёр. Нийгмийн ажилтны хүлээх үүрэг

2.1. Асруулагчийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд тэтгэмж олгох хугацааг эмч, эмнэлгийн байгууллага тухайн иргэний эрүүл мэндийн байдлаас шалтгаалан 6 сараас 36 сар хүртэл хугацаагаар тогтоох буюу сунгана.

2.2. Төрөлхийн оюуны хөгжлийн бэрхшээлтэй болон эдгэшгүй хүнд өвчтэй иргэнд байнгын асаргаа шаардлагатай хугацааг 36 сараар тогтоож, мөн хугацаагаар

сунгаж тэтгэмжийг Засгийн газраас тогтоосон хэмжээгээр сар бүр, банкаар дамжуулан олгоно.

2.3. Гэрээг сумын ерөнхий эмч, дүүргийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын комиссын шийдвэрт заасан хугацаагаар, ХХҮХ-ийн үнэлгээний дүн, гэрээг сунгах зөвшөөрөл, Амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэрийг үндэслэн тухай бүр сунгана.

2.4. Асрагчийн үзүүлж буй үйлчилгээний чанар, асруулагчийн сэтгэл ханамжийн байдалд үнэлгээ хийж, хяналт тавьж тэмдэглэл хийж хувийн хэрэгт хавсаргана.

2.5. Асрагчийн асаргаа үйлчилгээ үзүүлэх чадварыг дээшлүүлэхэд анхаарч сургалтанд хамруулна.

2.6. Асрагч, асруулагч нарт Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль, тогтоомж тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан эрх зүйн актын талаар мэдээлэл өгнө.

2.7. Хариуцлага, санаачлагатай ажиллаж гэрээнд заасан үүргээ амжилттай биелүүлсэн асрагчид зохих урамшуулал үзүүлж, үйлчилгээний арга туршлагыг нь сум, хороонд нэвтрүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах ажил зохион байгуулна.

2.8. Асрагч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, үйлчилгээний доголдол гаргаж асруулагчийг хохироосон, асруулагчийн бие элааршиж байнга асрах шаардлагагүй болж эмнэлгийн хяналтаас гарсан, бие даан амьдрах чадвартай болсон, асруулагч нас барсан тохиолдолд гэрээг хугацаанаас өмнө цуцалж асаргааны тэтгэмжийг зогсооно.

Гурав. Асруулагчийн хүлээх үүрэг

3.1. Асрагчийн ажилласан цаг, үзүүлсэн үйлчилгээг өдөр тутам бүртгэж, санал хүсэлт, сэтгэгдлийн хамт сарын эцэст нийгмийн ажилтанд өгнө. Энэ нь асрагчид тэтгэмж олгох нөхцөл болно.

3.2. Асрагчтай байх хугацаанд эмнэлгийн хяналтанд тогтмол үзүүлж эмчилгээг цаг хугацаанд нь бүрэн хийлгэж асаргааны тэтгэмж олгох хугацаа дуусахад бие даан амьдрах боломжтой болоход анхаарна.

3.3. Гэрийн хаяг өөрчлөгдөх, өөр газар шилжин суурьших болсон тохиолдолд энэ тухайгаа нийгмийн ажилтанд 14 хоногийн өмнө мэдэгдэнэ.

Дөрөв. Асрагчийн хүлээх үүрэг

4.1. Асруулагчийн ая тухтай байдлыг хангахад чиглэгдсэн:

- хүнсний зүйл цуглуулах, хоол хийх, хооллох,
- хувцас, цагаан хэрэглэлийг угаалга цэвэрлэгээнд хүргэж өгөх, авч ирэх, хувцаслах, хуурайлах
- орон гэрийг цэвэрлэх, цонх, хаалга дулаалах
- агаар нар салхинд гаргах усанд оруулах, үс засуулах
- сонин хэвлэл захиалан уншуулах, шуудан, номын сангийн үйлчилгээ авахад нь туслах, үзвэр үзүүлэх, тоглоом тоглуулах зэрэг чөлөө цагийг нь зохистой өнгөрүүлж уйдаж ганцаардахгүй байлгах
- орон сууцны хөлс төлөх, түлээ, нүүрс худалдан авах, мод хөрөөдөж хагалахад нь туслах
- асруулагчид тохирсон хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх
- зөв өтлөхүйн болон эрүүл мэнд, амьдрах ухааны зэрэг сургалт үйлчилгээнд хамруулах зэрэг өдөр тутам зайлшгүй шаардагдах асаргаа үйлчилгээг тогтмол үзүүлнэ.

4.2. Асруулагчийн хяналтын эмнэлэг, эмчтэй байнга холбоотой байж тогтоосон хугацаанд нь үзүүлэх, эмчилгээг тогтмол хийлгэж эрүүлжүүлэхэд анхаарч ажиллана.

4.3. Асруулагчийн биеийн эрүүл мэнд, сэтгэл зүйд гарч буй өөрчлөлт, мөн түүнтэй ажиллахад тохиолдсон хүндрэл бэрхшээл, ололттой сайн талд дүгнэлт хийж үйл явцын тэмдэглэл хөтөлж нийгмийн ажилтанд танилцуулна.

4.4. Гэр бүлдээ авч асрамжилж байгаа асруулагчийг гэр бүлийн харилцаанд жигд оролцуулж эрх, үүргийг нь эдлүүлж хүндэтгэлтэй хандана.

Тав. Хамтран хүлээх үүрэг

5.1. Энэхүү гэрээг сум, хорооны нийгмийн ажилтан, асрагч, асруулагч нар гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох бөгөөд энэ өдрөөс эхлэн гэрээгээр хүлээсэн тус тусын үүргээ хэрэгжүүлнэ.

5.2. Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах асуудлаар хийсэн хавсралт гэрээний салшгүй хэсэг болох бөгөөд адил хүчинтэй байна.

5.3. Энэхүү гэрээг гурван хувь үйлдэж, талууд тус бүр холбогдох хувийг хадгална.

5.4. Гэрээгээр хүлээсэн үүрэг биелэгдсэн, хугацаа дууссан эсвэл энэ гэрээний 2.7-д заасан үндэслэлээр гэрээ дуусгавар болно.

5.5. Гэрээний хэрэгжилттэй холбогдон гарах аливаа маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Гэрээ байгуулсан:

..... аймаг, дүүргийн сум, хорооны

Нийгмийн ажилтан

Асруулагч

Асрагч

/...../

/...../

/...../

Утасны дугаарУтасны дугаар Утасны дугаар

..... оны дугаар сарын-ны өдөр

Гэрээг оны дугаар сарын-ны өдрөөс оны

дугаар сарын-ны өдөр хүртэл сунгав.

Нийгмийн ажилтан

Асруулагч

Асрагч

/...../

/...../

/...../

Утасны дугаарУтасны дугаар Утасны дугаар

..... оны дугаар сарын-ны өдөр

БАТЛАВ. АЙМАГ, ДҮҮРГИЙН ХХҮХ-ИЙН ДАРГА / /

ХҮҮХЭД АСРАН ТЭТГЭХ ГЭРЭЭ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Гэрээний зорилго нь: Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.2.2-д заасан хүүхдийг /цаашид хүүхэд гэнэ/ Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд асаргааны тэтгэмж олгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. аймаг, дүүргийн сум, хорооны нийгмийн ажилтан овогтой /цаашид нийгмийн ажилтан гэнэ/, хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа аймаг, дүүргийн сум, хорооны иргэн /иргэний үнэмлэх № регистрийн №...../ овогтой..... /цаашид асрамжлагч гэнэ/ бид харилцан тохиролцож, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох тухай сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөл, Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор энэхүү гэрээг байгуулав.

1.3. Гэр бүлдээ авч асрамжлах хүүхдийн нэрсийн жагсаалт

д/д	Овог нэр	Регистр, гэрчилгээ дугаар	Хүйс	Асрамжлуулах болсон шалтгаан	Асрамжлах хугацаа
1					
2					
3					

Хоёр. Нийгмийн ажилтны хүлээх үүрэг

2.1. Хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд тэтгэмж олгох хугацааг өргөдөл гаргасан өдрөөс эхлэн 12 сараар тогтоож, асрамжлагчийн оршин суугаа харьяаллын дагуу асаргааны тэтгэмжийг Засгийн газраас тогтоосон хэмжээгээр сар бүр, хүүхэд тус бүрт банкны байгууллагаар дамжуулан олгоно.

2.2. Гэрээнд хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэний хүсэлт, Амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр, ХХҮХ-ийн үнэлгээний дүн, гэрээг сунгах зөвшөөрлийг үндэслэн тухай бүр сунгана. Хүүхдийг байнга асрамжлах шаардлагатай бол 18 нас хүртлэх хугацаанд тэтгэмж олгоно

2.3. Асрамжлагчийн хүүхэд асран хүмүүжүүлж буй байдал, хүүхдийн сэтгэл ханамжийн байдалд үнэлгээ хийж, хяналт тавьж тэмдэглэл хийж хувийн хэрэгт хавсаргана.

2.4. Асрамжлагчийн асран хүмүүжүүлэх чадварыг дээшлүүлэхэд анхаарч сургалтанд хамруулна.

2.5. Асрамжлагч нарт Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан эрх зүйн актуудын дагуу хүүхэд тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжид хэрхэн хамрагдах талаарх болон бусад мэдээлэл өгнө. Хүүхдэд олгох тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлтөд хамруулж хүүхдийн хөгжилд зарцуулж байгаа байдалд хяналт тавьж ажиллана

2.6. Хариуцлага санаачлагатай ажиллан гэрээнд заасан үүргээ амжилттай биелүүлсэн асрамжлагчид зохих урамшуулал үзүүлж, хүүхэд асран хүмүүжүүлэх арга туршлагыг нь сум, хороонд нэвтрүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах ажил зохион байгуулна.

2.7. Асрамжлагч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй хүүхдийг хохироосон, хүүхэд 18 нас хүрсэн, нас барсан хүүхдийн эцэг, эх эрх зүйн чадамжтай болсон, хязгаарлуулсан болон хасуулсан эрх нь сэргээгдсэн, ял эдлэх хугацаа нь дууссан, удаан хугацааны эмчилгээ нь дуусч, эрүүлжсэн тохиолдолд гэрээг хугацаанаас өмнө цуцалж, асаргааны тэтгэмжийг зогсооно.

Гурав. Асрамжлагчийн хүлээх үүрэг

3.1. Гэр бүлийн бүх гишүүд хүлээн зөвшөөрч, асрамжилж байгаа хүүхэдтэй халуун дотно харьцаатай байж, гэр бүлийн харилцаанд жигд оролцуулан эрх, үүргийг нь бүрэн эдлүүлнэ. /хүүхдийг шоовдорлох, гадуурхах, шоглох, үг хэлээр доромжлох, хөндий хүйтэн харьцах байдал гаргахгүй байх/

3.2. Хүүхдийн ая тухтай байдлыг хангаж, шаардлагатай хэмжээнд хооллох, хувцаслах, агаар, нар, салхинд гаргах, усанд оруулах, үс засуулах зэрэг наад захын хэрэгцээг нь хангана.

3.3. Хүүхдийг ерөнхий боловсрол эзэмшихэд нь анхаарч, өдрийн болон зайны сургалтанд тасралтгүй хамруулна. Сурагчийн форм, ном сурах бичиг, хичээлийн хэрэгслийг нь авч өгөх, бага насны хүүхдийг сургууль, цэцэрлэгт нь хүргэж өгөх, авах, секц дугуйланд явуулах, багш нартай нь холбоотой байж эцэг, эхийн хуралд суух зэргээр суралцах боломжийг нь бүрдүүлж өгнө.

3.4. Хүүхдийн зуслан, сувилалд явуулах, хүүхдэд зориулсан сонин, сэтгүүл захиалан уншуулах, номын санд суулгах, үзвэр үзүүлэх, тоглоом тоглуулах зэрэг чөлөө цагийг ив зохистой өнгөрүүлж уйдаж, ганцаардахгүй байлгана.

3.5. Хоол хийхэд туслах, аяга таваг угаах зэрэг хүүхдэд тохирсон гэрийн ажил хийлгэж амьдрах ухаанд сургана.

3.6. Баг, хорооны эмчтэй байнга холбоотой байж, хүүхдийг тогтоосон хугацаанд нь үзүүлж, шаардлагатай эмчилгээг хийлгэж, вакцинжуулалтанд тогтмол хамруулж, бага насны хүүхдээр харуулах ба хараа хяналтгүй орхихгүй байж аливаа халдлага, хүчирхийлэл, аваар ослоос урьдчилан сэргийлж эрүүл мэнд, амь насыг хариуцаж хамгаална.

3.7. Хүүхдийн биеийн эрүүл мэнд, сэтгэл зүйд гарч буй өөрчлөлт, сурлагын байдал мөн түүнийг асрамжлахад тохиолдсон хүндрэл бэрхшээл, ололттой сайн талд дүгнэлт хийж үйл явцын тэмдэглэл хөтөлж нийгмийн ажилтанд танилцуулна.

Дөрөв. Хамтран хүлээх үүрэг

4.1. Энэхүү гэрээ нь сум, хорооны нийгмийн ажилтан, асрамжпагч нар гарын үсэг зурж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга баталснаар хүчин төгөлдөр болох бөгөөд энэ өдрөөс эхлэн гэрээгээр хүлээсэн тус тусын үүргээ хэрэгжүүлнэ.

4.2. Гэрээг хэрэгжүүлэхэд холбогдох асуудлаар бичгээр хийсэн хавсралт гэрээний салшгүй хэсэг болох бөгөөд адил хүчинтэй байна.

4.3. Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж, талууд тус бүр холбогдох хувийг хадгална.

4.4. Гэрээгээр хүлээсэн үүрэг биелэгдсэн, хугацаа дууссан эсвэл энэхүү гэрээний 2.7-д заасан үндэслэлээр гэрээ дуусгавар болно.

4.5. Гэрээг Монгол хэлнээс бусад улсын хэлэнд орчуулж хэрэглэсэн бол энэ гэрээний Монгол хэл дээрхи хувилбар нь бусад хэлнүүд дэх орчуулгын хувилбараас давуу эрхтэй байна.

4.6. Гэрээний хэрэгжилттэй холбогдон гарах аливаа маргааныг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу харьяалагдах Монгол улсын шүүхээр хянан шийдвэрлүүлнэ.

Гэрээ байгуулсан:

..... аймаг, дүүргийн сум, хорооны

Нийгмийн ажилтан

Асрамжлагч

/...../

/...../

Утасны дугаар

Утасны дугаар

..... оны дугаар сарын-ны өдөр

Гэрээг оны дугаар сарын-ны өдрөөс оны

дугаар сарын-ны өдөр хүртэл сунгав.

Нийгмийн ажилтан

Асрамжлагч

/...../

/...../

Утасны дугаар

Утасны дугаар

..... оны дугаар сарын-ны өдөр

Гэрээг оны дугаар сарын-ны өдрөөс оны

дугаар сарын-ны өдөр хүртэл сунгав.

Нийгмийн ажилтан

Асрамжлагч

/...../

/...../

Утасны дугаар

Утасны дугаар

..... оны дугаар сарын-ны өдөр

Гэрээг оны дугаар сарын-ны өдрөөс оны
дугаар сарын-ны өдөр хүртэл сунгав.

Нийгмийн ажилтан

Асрамжлагч

/...../

/...../

Утасны дугаар

Утасны дугаар

..... оны дугаар сарын-ны өдөр

Гэрээг оны дугаар сарын-ны өдрөөс оны
дугаар сарын-ны өдөр хүртэл сунгав.

Нийгмийн ажилтан

Асрамжлагч

/...../

/...../

Утасны дугаар

Утасны дугаар

..... оны дугаар сарын-ны өдөр